



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дугаар заалт, “Агентлаг байгуулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоол, “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Мэргэжлийн хяналтын байгууллагаас шилжин ирсэн албан хаагчдын хувийн хэрэг, Эм шинжлэх лабораторийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, лабораторийн урвалж, стандарт бодис, холбогдох материалыг хүлээлцэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Холбогдох материал, багаж, тоног төхөөрөмжийг хүлээлцэх ажлыг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулж, танилцуулахыг ажлын хэсэг (П.Буяндэлгэр)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Намхайноров)-т даалгасугай.

ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ДЭД ДАРГА



Д.УРАНЗАЯА

142022 01008